



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ЧОЙДОГЖАМЦЫН ТУУЛ ТАНАА**

2020.09.03 № СНА-2020/06-НН-92
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Чойдогжамцын Туулын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Ч.Туул нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020871


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Ч.Туулын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Ч.Туулын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЧОЙДОГЖАМЦЫН
ТУУЛЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Зорилт-1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ.

- 1.1. Сумын Эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн ажилчдын ур чадварыг дээшлүүлэн хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийг үе шаттай бууруулахад анхаарч ажиллана.
- 1.2. Хөдөөгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, хүртээмжийг сайжруулж эрүүл мэндийн үйлчилгээний чанарт иргэдийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлэхэд санаачилгатай ажиллана.
- 1.3. Байнгын асаргаанд байгаа хэвтэрийн өвчтэй ХБИ, ахмад настанд эмнэлгийн зүгээс үзүүлж байгаа тусламж үйлчилгээнд хяналт тавьж гэрийн эргэлтийг сайжруулна.
- 1.4. Сэтгэл зүйн болон эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн сургалт, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Зорилт-2 Боловсролын салбарын сургалтын чанар орчныг сайжруулна.

- 2.1 ЕБС, цэцэрлэгт эмч ажиллуулж хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл аюулгүй орчинд сурах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.
- 2.2 Насан туршийн боловсролын үйл ажиллагааг хэвийн тогтмол явуулж иргэдэд чиглэсэн амьдрах ухааны сургалтуудыг хөтөлбөрийн дагуу явуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 2.3 Багшийн заах арга ур чадварыг сайжруулах, сургалтын таатай орчин бүрдүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллана.
- 2.4 Соёлын төвийг мэргэжилтэй боловсон хүчнээр бүрэн хангах асуудлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

Зорилт-3 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, тогтвортой ажлын байраар хангах, хөдөө аж ахуй байгалийн баялгийн нөөцөд тулгуурлан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжинэ.

- 3.1 Ард иргэдийн хөдөлмөр эрхлэлт, амжиргааны түвшний судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран гаргаж, ажлын байр бий болгох, өрхийн болон иргэдийн амжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж, жилд 2 удаа иргэдэд үр дүнг нь тайлагнана.
- 3.2 Хөдөлмөрөөрөө хоршин бүлэг хоршоо байгуулах, экологид ээлтэй бүтээгдэхүүн хийж үйлдвэрлэх иргэдийн санал санаачилгыг өрнүүлэн тэдгээрийг төрийн болон төрийн бус байгууллагуудын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 3.3 Суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагыг сайжруулан чанаржуулж, ажлын байр бий болгох, айл өрхийг

- амжиргааны эх үүсвэртэй болгох, иргэд ая тухтай, эрүүл мэндэд ээлтэй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагааг нь чиглүүлэхийг дэмжинэ.
- 3.4 Иргэдийн шинээр газар өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлэхдээ эрчим хүч, дэд бүтцийн асуудлыг хамтад нь шийдвэрлүүлэх гарц боломжийг эрэлхийлж ажиллана.
- 3.5 Орон нутагт хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлэх, ялангуяа эх оногоо тариалах хөдөлгөөнийг дэмжиж, ногооны хадгалалтын нөхцөлийг бүрдүүлэх бодлого үйл ажиллагааг дэмжинэ.
- 3.6 “Хашаанаасаа 50 сая” хөдөлгөөнд нэгдсэн иргэд, өрхийг дэмжиж, хамтран ажиллана.
- 3.7 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний нийгэмд эзлэх байр суурь, хүчирхийллээс ангид байх, хамгаалагдах орчныг бүрдүүлэх чиглэлээр санал, санаачилга гаргаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 3.8 Сумын төвийн хогийн цэгийн асуудлыг нэн даруй шийдвэрлэж, ойр орчмын айл өрхүүдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ авна.
- 3.9 Ундны усны чанар, гүний худгуудын ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөл, хамгаалалтын байдалд хяналт тавьж, сайжруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 3.10 Мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллагуудыг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үртэс болон бусад үлдцүүдийг ашиглан, хаягдалгүйгээр экологид ээлтэй технологийг нэвтрүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжинэ.
- 3.11 Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон захиргааны байгууллагын аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь шударга ёс, хууль дээдлэх зарчмын хүрээнд явагдаж байгаа эсэхэд иргэдийн оролцоо дэмжлэгтэйгээр хяналт тавьж, одоогийн “Нам”-ын бодлого нэрээр халхавчилсан алдаа зөрчлүүдийг засах, гаргуулахгүй байх талаар санаачилгатай ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

Ч. Туул

Ч. ТУУЛ